

Сүр жавхлангийн тухай Кантын ойлголтыг орчин үеийн гоо зүйн онолд холбогдуулан тайлбарлах нь

Б.Дагзмаа, доктор (Ph.D), профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Г.Хонгорзул, магистрант
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: Гоо зүйн сүр жавхлангийн тухай ойлголтыг Кант өвөрмөцөөр тодорхойлсноороо философийн түүхэнд алдартай билээ. Түүний Бодомжийн чадварын шүүмж зохиолдоо боловсруулсан сүр жавхлангийн тухай ойлголт нь байгаль болон эрх чөлөөний хүрээг холбодгоороо ач холбогдолтой. Сүр жавхлангийн математик ба динамик гэх хоёр төрлөөр дамжуулан Кант энгийн сэрэл хүртэхүйг давуулан хэрхэн гоо зүйн туршилага бий болж байгааг харуулсан. Математик сүр жавхлан нь туйлын агуу зүйлийн бүхэллэг байдлыг эрэлхийлэх бололцоог дүрслэн бодохуйд олгодог бол динамик сүр жавхлан нь байгалиас давсан практик оюун ухааны чадамжийг бидэнд сануулж өгдөг. Кантын хувьд, сүр жавхлан нь объектод өөрт нь бус, гагцхүү бидний оюун санаанд л оршдог. Сүр жавхлангийн тухай бодомж нь цэвэр гоо зүйн бодомж учир субъектив түгээмэл, зайлшгүй, үл сонирхохуй болон зорилгод нийцэх чанарт тулгуурладаг. Сүр жавхлангийн тухай үзэл нь Германы романтикуудад хүчтэй нөлөө үзүүлсэн хэдий ч яваандаа гоо зүйн төв асуудал байхаа больжээ. Бид орчин үеийн гоо зүй дэх атомын сүр жавхлан, авангард сүр жавхлан болон технологийн сүр жавхлангийн тухай ойлголтууд нь сүр жавхлангийн тухай Кантын ойлголтоос утгын эхээ авсан гэж үзсэн юм.

Түлхүүр үг: эргэцүүлэгч бодомж, гоо зүйн бодомж, сайхан, сүр жавхлан, дүрслэн бодохуй, авангард сүр жавхлан, технологийн сүр жавхлан

Оршил

Мэдлэг болон ёс суртахууны зарчмыг бүтэцжүүлэхэд хүний оюун санааны идэвхтэй үйл ажиллагаа гол үүрэг гүйцэтгэдгийг онцолдог Иммануил Кантын философи үзэл орчин үеийн философийн тулгуур болсон юм. Энэ утгаараа танигдан мэдэгдэгч объект болон танин мэдэгч субъектээс үл хамаармал ёс суртахууны зарчмын эх сурвалжийн тухай ойлголтуудад шүүмжлэлтэй хандсан билээ. Цэвэр оюун ухааны шүүмж зохиолоос бид хүн бээр феномен болохын хувьд оюун бодлын¹⁵ байгалийн үзэгдлүүдэд оноодог шалтгаацид мөн адил захирагддаг тухай, Практик оюун ухааны шүүмж зохиолоос хүн бээр ноумен болохын хувьд оюун ухаанд суурилсан шийдвэр гаргаж, ёс суртахууны үүргийн дагуу үйлдэх эрх чөлөөтэй болох тухай ойлголтыг олж авсан бол үүнээс үүдэх “хүн шийдвэрлэлтэд”¹⁶ захирагдах атлаа эрх чөлөөтэй үйл эрхлэгч байдлаар хэрхэн оршин тогтнодог вэ?” гэх асуултад хариулахын тулд Кант

¹⁵ Герман хэлний *Verstand*, англи хэлний *understanding* гэх уг ойлголтыг Гомбосүрэн, Ц. (2024) *оюун бодол*, Даваадаш, Ч. (2024) *оюун бодол, бодвор* хэмээн буулгасан байдаг.

¹⁶ *Bestimmung* буюу *determination* нь оюун санаа үзэгдлүүдийг хэрхэн идэвхтэйгээр бүтэцжүүлж, тодорхойлж байдгийг илтгэх ба нэг талаас бидний оюун санаа байнгын шийдвэр гаргадаг, нөгөө талаас бид үзэгдэл болохын хувьдаа шийдвэрт захирагдаж байдаг.

Бодомжийн чадварын шүүмж¹⁷ зохиолдоо бодомжийн чадварын эргэцүүлэгч¹⁸ үйлд анхаарлаа хандуулсан юм. Гоо зүйн бодомж¹⁹ нь энэхүү эргэцүүлэгч бодомжийн нэгэн онцлог хэлбэр болохын хувьд байгалийн ертөнцийг ёс суртахууны ертөнцтэй холбодог хэмээн Кант үзсэн. Харин энэхүү холбоог сүр жавхлангийн²⁰ туршлага илүү нарийн гаргаж өгдөг болно.

Нөгөө талаас, Никола Буалу болон Жон Деннис нарын нөлөөгөөр XVIII зуунаас гоо зүйд сүр жавхлангийн тухай ойлголтыг хэрэглэх болсон ба Эдмунд Бюрк (1757) анхлан тус ойлголтыг сайхны тухай ойлголттой харьцуулан, системтэйгээр авч үзсэн байдаг. Түүний дараагаар, Кант

¹⁷ Паул Гаеэр, Эрик Мэттьюс нар *Kritik der Urteilstkraft* (1790) гэх тус зохиолыг 2000 онд *Critique of the Power of Judgment* хэмээн орчуулах хүртэл англи хэлэнд *Critique of Judgment* хэмээн орчуулж байжээ. *Power of judgment*-ийг Энхбаатар, А. (2015) *эргэцүүлэх чадвар*, Төмөрбаатар, Ж., Дэлгэрмаа, Б. нар (2007) *бодомж буюу шүүн бодох чадвар* хэмээн орчуулсан байдаг. *Urteilstkraft* буюу *Power of judgment* гэх ойлголт нь *judgment*-ийг бий болгох бидний чадварыг илтгэдэг ба априори, апостериори бодомжийг *a priori judgment*, *a posteriori judgment* хэмээн нэрлэдэг тул *judgment*-ийг *бодомж*, *power of judgment*-ийг *бодомжийн чадвар* хэмээн орчуулах нь оновчтой хэмээн үзэв. Харин гоо зүйн бодомж нь хэлбэрийн хувьд априори ч эмпирик туршлагыг шаарддаг өвөрмөц хэлбэрийн бодомж юм.

¹⁸ Кант *Цэвэр оюун ухааны шүүмж* зохиолдоо бодомжийн чадварыг оюун бодлын дүрэмд захирагдан аливаа үзэгдэлд ойлголт оноох үүрэгтэй хэмээн үзэж байсан бол *Бодомжийн чадварын шүүмж* зохиолдоо тус бодомжийг *шийдэгч бодомж* (*determining judgment*) хэмээн нэрлэсэн. Учир нь би “энэ бол чацаргана” хэмээн шүүн дүгнэхэд миний сэрлүүдэд өгөгдсөн уг зүйлийг “чацаргана” гэх ойлголтод багтах эсэхийг шийдэж буй хэрэг юм. Харин Кант удаах зохиолдоо *reflective judgment* хэмээх бодомжийн хэлбэрийг шинээр танилцуулсан юм. Энэ нь аливаа объект, үзэгдлийг уялдуулах ойлголт байхгүйн улмаас шинээр ойлголтыг эрэлхийлэхдээ субъект өөртөө эргэцүүлэл хийснээр бий болдог бодомж тул *эргэцүүлэгч бодомж* хэмээн орчуулав. Тус бодомж нь бодомжийн чадварын эргэцүүлэгч үйлийн үр дагавар болно.

¹⁹ *Бодомжийн чадварын шүүмж* зохиолдоо Кантын боловсруулсан сайхан болон сүр жавхлангийн тухай онол нь гоо зүйн шинж чанар, аль эсвэл субъектив туршлага гэгддэг сайхан болон сүр жавхланг бус, бидний оюун санааны чадваруудын идэвхтэй тоглолтын дүнд бий болдог сайхан болон сүр жавхлангийн тухай бодомжийг гол асуудлаа болгон үздэг тул түүний танин мэдэхүйн онолтой нягт холбоотой. Түүнчлэн, бодомжийн чадвар нь цэвэр оюун ухаан болон практик оюун ухааны холбоог боломжтой болгодог тул түүний ёс суртахууны философитой ч холбогддог. Энэ утгаар сайхан болон сүр жавхлангийн тухай асуудлыг түүний шүүмжлэлт философиос тусад нь авч үзэх боломжгүй тул цэвэр гоо зүйн онол хэмээн үзэх нь учир дутагдалтай авч субъектэд төрөх таашаалын догдлон мэдрэхүйд суурилдаг тул тус зохиол дахь *aesthetic* гэх ойлголтыг *гоо зүй* хэмээн орчуулав. Харин *Цэвэр оюун ухааны шүүмж* зохиолдоо Кант *transcendental aesthetic* гэх ойлголтыг сэрэл мэдрэхүйгээр дамжуулан танин мэдэж болох зүйлсийн хүрээ байдлаар үзэж байсан тул энэ нь танин мэдэхүйн бодомжтой холбогдоно. Иймд *Бодомжийн чадварын шүүмж* зохиол дахь *aesthetic* гэх ойлголт нь *Цэвэр оюун ухааны шүүмж* зохиол дахь *aesthetic* гэх ойлголтоос утгын хувьд ялгаатай болно.

²⁰ Гоо зүйн онолын үндсэн категориудын нэг болох *das Erhabene* буюу *the sublime*-ыг монгол хэлэнд *гайхамшигт зүйл*, *гайхамшигтай*, *бадрангуй* хэмээн орчуулсаар ирсэн билээ. Этимологийн хувьд *дээш өргөгдсөн* гэх утгыг илэрхийлдэг тус ойлголтын тухай Лувсанвандан, В. (1964) “...Байгалийн үнэн байдал, нийгмийн бодит сүр жавхлантай үзэгдэл, урлагийн гайхамшигт төгөлдөр бүтээлүүд уг категорийн бодитойгоор оршин байдгийг илтэд харуулж байна. Од мичид яралзан түгсэн гүн шөнийн тэнгэр, хүний хараа булаасан хөх цэнхэр огторгуйн уудам сүрлэг бишүү?...агуу их Октябрийн хувьсгал хүн нийгмийн сүрлэг жавхлантай үзэгдэл биш үү?...” хэмээн бичсэн бол Төмөрбаатар, Ж. (1998) “...энэ ойлголтын агуулгад бадрангуй, жавхлантай, сүрлэг сайхан байх чанарууд багтаж ордог...” хэмээн бичсэн байдаг. Дэлгэрмаа, Б. (2022) “...хүн бодож бясалгасны эцэст гайхан бахдах, сүслэн бишрэхийн сацуу түүний ойлгох, хүртэх хэмжээнээс хэтийдсэн юмс үзэгдлийн өмнө айж сүрдэх, сандарч чичрэх, гэгээн онгод төрөх нарийн төвөгтэй мэдрэмжийг хэлнэ...” хэмээсэн. *The Sublime* гэх ойлголтыг Википедиа толь бичигт “...бүхий л тооцоолол, хэмжилт, эсвэл дуурайлтаас давсан агуу байдлыг илтгэнэ...” хэмээн тодорхойлсон бол Шай (2006) “...үгс хүчгүйдэж, харьцуулалтын цэгүүд үгүй болох үед энэхүү догдлон мэдрэхүй бий болно...таньж харах, мэдэх, бодол юм уу биеийн мэдрэмжээ илэрхийлэх чадвар дийлдэх агшныг илэрхийлнэ...” хэмээн онцолсон. Доран (2015) тус ойлголтыг “...өндөрлөг (*loftiness*), оргил (*height*), өргөлт (*elevation*) хэмээх утга бүхий эл ойлголт хөөрөл (*ecstasy*), жавхлантай байдал (*grandeur*), айдас хүйдэс (*terror*), сүрдэлт (*awe*), алмайрал (*astonishment*), гайхширал (*wonder*), бишрэлийн (*admiration*) ухагдахуунтай холбогддог...” хэмээжээ. Ийнхүү хэмжээ, эсвэл хүчний хувьд давамгай, айдас хүйдэс, таашаалыг нэгэн зэрэг догдлон мэдрэх боломжийг олгодог, өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааг сааталд оруулах агуу байдлыг илтгэдэг уг гоо зүйн туршлагын боломжит орчуулгуудаас *сүр жавхлан* хэмээх орчуулгыг илүү оновчтой хэмээн үзсэн болно.

сайхан болон сүр жавхлангийн туршлагыг хувь хүний мэдрэмжид, аль эсвэл объектод *биш*, харин хүний оюун санааны чадваруудад тулгуурлан тайлбарласан нь гоо зүйн онолын хүрээнд ихээхэн онцлог явдал байв. Сайхны нэг хэлбэр байдлаар үнэлэгддэг байсан сүр жавхлангийн тухай ойлголтыг ийнхүү гоо зүйн бие даасан ойлголт байдлаар авч үзэх болсон нь орчин үед ямар нөлөө үзүүлснийг тайлбарлах шаардлагатай билээ.

Сайхан болон урлагийн тухай асуудлыг пифагорчууд, Ксенофон зэрэг Сократаас өмнөх үеийн философичид анхлан хэлэлцэж эхэлсэн ч эдгээр асуудал XVIII зуун хүртэл философийн бие даасан салбарт тооцогддоггүй байв. Харин Александр Баумгартен сэрэл хүртэхүйг илэрхийлдэг грек хэлний *aisthesis* гэх ойлголтод тулгуурлан *aesthetics* гэх нэр томьёог танилцуулахдаа *сэрлүүдээр мэдэрсэн, мөн дүрслэн бодсон зүйлсийн тухай мэдлэг ухаан* (Guyer, 2020) хэмээн тодорхойлсон. Энэ үеэс гоо зүй нь энгийн хэлэлцүүлгийн хүрээнээс философийн бие даасан салбар ухаан болон хөгжих эхлэл тавигдсан юм. Ингэснээр сайхан болон урлагаас гадна гоо зүйн мэдрэмж²¹ болон сүр жавхлангийн тухай асуудлыг системтэйгээр авч үзэх нөхцөл бүрджээ.

Сүр жавхлан нь зөвхөн гоо зүйн хэлэлцүүлгийн сэдэв байсангүй. ХТ I зууны үед хамаарагдах *Сүр жавхлангийн тухай*²² гэдэг зохиолд сүр жавхланг утга зохиол, уран илтгэхүйн ухаантай холбож, уншигч, сонсогчдын оюун санаа, сэтгэлийн хүч тэнхээг нэмэгдүүлж, тэдэнд сүрдэм, жавхлантай мэдрэмж төрүүлэх зохиолч, уран илтгэгчийн чадвар байдлаар үзэж байжээ. Мөн сүр жавхланг *агуу сэтгэлийн цуурай* хэмээн тодорхойлж, зохиомж, найруулгаар давамгайл байхаас гадна уншигч, сонсогчдод гүнзгий сэтгэл хөдлөл, таашаал төрүүлдэг байх хэрэгтэй хэмээнээр зохиолч, уран илтгэгчийн бүтээлч чадварыг онцолж байсан юм. (McMahon, 1998)

Тус зохиолыг 1674 онд яруу найрагч, утга зохиолын шүүмжлэгч Никола Буалу франц хэлэнд орчуулсан ба орчуулгынхаа удиртгалд *сүр жавхлант хэв маяг* нь агуу үгсийг шаарддаг бол *сүр жавхлан* нь гагцхүү бодол санаанд, эсвэл хэлбэр юм уу илэрхийллийн эргүүлэгт л байна хэмээн ялгаж өгсөн юм. Улмаар сүр жавхлан гэх ойлголтыг утга зохиол шүүмжлэлийн салбарт, мөн дараа нь бий болсон гоо зүйн салбарт зээлдэн ашиглах нөхцөлийг бүрдүүлж өгчээ. (Doran, 2015)

Харин шүүмжлэгч, жүжгийн зохиолч Жон Деннис 1688 онд “...Байгал мөн ширүүн догшин, сүйтгэгч шинжтэй харагдсан. Тэр үед бид үнэнхүү утгаар сүйрлийн ирмэгт ирж, бүдрэх л юм бол амьдрал хийгээд бие махбод нэгэн зэрэг сүйднэ гэдгийг ухаарах тэр үед дотор минь нэгэн зэрэг тааламжит аймшиг, айдас хүйдэст баяр баясал гэх өөр өөр мэдрэмж бий болж, би хязгааргүйгээр таашаал мэдэрч, чичирхийлж байв...” хэмээн Альпийн нуруунд аялах үеийн тэмдэглэлдээ бичсэн нь сүр жавхланг тааламжит аймшиг, айдас хүйдэст баяр баясал гэх холимог мэдрэмж, хүчтэй сэтгэл хөдлөлтэй холбож, улмаар хожим гоо зүйн категори болсон сүр жавхлангийн үндсэн шинжийг тодорхойлж өгсөн юм.

Сүр жавхланг анх гоо зүйн бие даасан ойлголт болгон боловсруулсан философич бол Эдмунд Бюрк хэмээн үздэг. Тэрээр Жон Локкын “зовуурьтай зүйл таашаалтай биш, таашаалтай зүйл өвтгөдөггүй” гэх үзлийг шүүмжилж, нэг нь нөгөөдөө хувирч боломгүй мэдрэмжүүдийг хольж догдлон мэдрэх боломжтойг онцолсоноороо сайхан болон сүр жавхланг ялгаж үзсэн юм. Ингэхдээ зовуурийг үгүй хийсэн ч гэсэн ул мөрөө үлдээдэг ба тэр үед төрөх таашаалыг сэтгэл тэнийх²³ хэмээн нэрлээд, түүнийг эерэг таашаалаас ялган үзсэн юм. Аливаа зовуурь, аюул нь сүр

²¹ *Taste* гэдэг нь гоо зүйн салбарт сайхныг анзаарах, ялган таних, мөн үнэлэх бололцоо олгодог бидний чадварыг илэрхийлнэ. Үүнийг сайхныг эсвэл урлагийн бүтээлийг “амтлах” мэдрэмж хэмээн үзэж болох тул *мэдрэмж* хэмээн орчуулав.

²² Тус зохиолын зохиолчийн тухай мэдээлэл тодорхой бус байдаг ч Лонжинус нэртэй хүн бичсэн хэмээн таамагладаг.

²³ *Delight*

жавхлангийн эх сурвалж болдог бөгөөд сүр жавхлан нь сэтгэл тэнийх мэдрэмжийг зайлшгүй шаарддаг боловч сэтгэл тэнийх мэдрэмж бүр сүр жавхланд хамаарахгүй. Гэхдээ хэрэв ийнхүү холбогдох л юм бол тэр нь аюулгүй байдлын нөхцөл дэх зовуурийн тухай санааг гагцхүү агуулна. (Doran, 2015) Өөрөөр хэлбэл, сүр жавхланд өгөгдмөл байдаг сүрдэлт, айдас хүйдсийн догдлон мэдрэхүй нь аюул, зовууриас холдсон үед тухайн хүний сэтгэл тэнийхэд хүргэж, улмаар таашаалтай туршлага болдог. Ийнхүү Бюрк сайхны тухай бодомж нь зөвхөн таашаалд суурилдаг, сүр жавхлангийн тухай бодомж бол таашаал, зовуурь аль алинд нь суурилдаг хэмээн үзжээ. (Zangwill, 2023) Сайхан зүйл хэмжээгээр бага, өө сэвгүй, гэгээлэг, зөөлөн, гоёмсог байдаг бол сүр жавхлант зүйл хэмжээний хувьд асар их, харанхуй, бүүдгэр, хатуу, нүсэр байх ёстой. (Burke, 1757) Энэ утгаар Бюркийн хувьд сайхан болон сүр жавхлангийн бодомж нь объектив шинжтэй бөгөөд нэг нь нөгөөгөө багтаадаггүй, эрс эсрэгцэх харилцаатай.

Сүр жавхлангийн тухай Кантын ойлголтыг авч үзэхийн тулд түүний *Бодомжийн чадварын шүүмж* зохиолоо бичих болсон шалтгаан болоод гоо зүйн бодомжийн онцлогийг тайлбарлая. Хүний дээд түвшний танин мэдэхүйн чадамжуудад²⁴ оюун бодол, бодомжийн чадвар ба оюун ухаан багтана хэмээн Кант үзсэн юм. Оюун бодол нь оюун санааг ойлголтуудаар хангадаг бол бодомжийн чадвар нь ойлголтуудыг үзэгдлүүдтэй уялдуулдаг. Ингэснээр оюун ухаан гаргалгаа, дүгнэлт хийх боломжтой болох тул бодомжийн чадвар нь оюун бодлыг оюун ухаантай холбож өгдөг. Харин хүний оюун санааны ерөнхий чадамжуудыг Кант танин мэдэхүйн, таашаал, үл таашаалыг²⁵ догдлон мэдрэхүйн болон хүсэл эрмэлзлийн²⁶ хэмээн ангилсан байдаг. Таашаалыг догдлон мэдрэхүй нь ертөнцийн тухай бидний мэдлэгийг ертөнцөд үйл хэргээ удирдан чиглүүлэх хүсэл эрмэлзэл болж хувирахад сэтгэл хөдлөлийн түлхэц үзүүлдэг тул онолын ойлголт, мэдлэгийг практик үйл хэрэг, үйлдэл хийх сэдэл рүү чиглүүлж өгдөг. Иймд таашаал, үл таашаалыг догдлон мэдрэхүй нь мөн танин мэдэхүйн чадамжийг хүсэл эрмэлзлийн чадамжтай холбож өгдөг байна.

Кант *Цэвэр оюун ухааны шүүмж* зохиолдоо танин мэдэхүйн чадамжийн априори зарчмыг оюун бодлоос, *Практик оюун ухааны шүүмж* зохиолдоо хүсэл эрмэлзлэлийн чадамжийн априори зарчмыг оюун ухаанаас эрэлхийлсэн байдаг нь бодомжийн чадвар болон таашаал, үл таашаалыг догдлон мэдрэхүйд хоосон орон зай үлдээж байгаа ба эдгээр нь хоёул гагцхүү субъекттэй холбогддоогоороо онцлог юм.

Ойлголтуудаар дамжуулан танин мэдэх чадамжуудын хуваалтын хувьд оюун бодол болон оюун ухаан өөрсдийн репрезентация объектод холбогдуулан, түүний тухай ойлголтыг олж авдаг

²⁴ Герман хэлний *Kraft* болон *Vermögen* гэх ойлголтуудыг англи хэлэнд тус тус *power* болон *faculty* хэмээн орчуулсныг мөн ялган *чадвар* болон *чадамж* хэмээн буулгав. Учир нь *faculty* буюу *чадамж* нь оюун санааны потенциал, суурь чадлыг, *power* буюу *чадвар* нь чадамжийн хэрэгжилт буюу бодит үйл ажиллагааг илэрхийлдэг. Ертөнцийг үзэгдэл болохынх нь хувьд таньж мэдэх, түүний тухай мэдлэг олж авах чадваруудыг Кант репрезентацийн чадамжууд буюу танин мэдэхүйн чадамжууд хэмээн нэрлэдэг ба үүнийг дээд болон доод түвшинд хуваан ангилдаг. Хэрэв тухайн объектын нөлөөнд орсон даруй репрезентацитай болж байвал доод түвшний, харин оюун санаа өөрөөсөө репрезентаци бий болгож байвал дээд түвшний танин мэдэхүйн чадамж хэмээн үзсэн юм. (Dunn, 2024) Өөрөөр хэлбэл, доод түвшний танин мэдэхүйн чадамжууд нь оюун ухааны идэвхгүй буюу өдөөгчөөс шууд хүлээн авах, өдөөгчид шууд хариу үзүүлэх сэрлүүдэд тулгуурласан танин мэдэхүйн хэлбэрүүд бол дээд түвшний танин мэдэхүйн чадамжууд нь оюуны идэвхтэй, аяндаа явагддаг үйл ажиллагаа бөгөөд хүний танин мэдэхүйн хамгийн цогц, нарийн төвөгтэй, хийсвэр хэлбэрүүдийг бий болгодог.

²⁵ *Unlust* гэх тус ойлголтыг англи хэлэнд *pain* юм уу *displeasure* хэмээн орчуулдаг. Гэхдээ сүр жавхлангийн тухай Кантын ойлголтыг харгалзан үзвэл *pleasure* буюу *таашаал* үгүй байх нь заавал өвдөлт, зовуурийг бий болгохгүй. Иймд тус ойлголтыг *displeasure* буюу *үл таашаал* хэмээн орчуулав.

²⁶ Герман хэлний *Begehren* гэх ойлголтыг англи хэлэнд *desire* хэмээн орчуулсныг *дур хүсэл* бус *хүсэл эрмэлзэл* хэмээн орчуулав. Учир нь хүний үйлдлийг сэдэлжүүлж, чиглүүлэхэд дур хүсэл нөлөөлдөг ч энэ нь хүсэл эрмэлзэл гэх ерөнхий ойлголтод багтах болов уу хэмээн үзсэн юм. Түүнчлэн, Кантын ёс суртахууны философид гол байр суурь эзэлдэг *will* нь хүсэл эрмэлзлийн чадамжийн дээд хэлбэр болдог.

бол бодомжийн чадвар нь гагцхүү субъектэд холбогдох бөгөөд дангаараа объектын тухай ямар ч ойлголт бий болгохгүй. Үүний адилаар, хүний оюун санааны чадамжуудын ерөнхий хуваалтын хувьд танин мэдэхүйн болон хүсэл эрмэлзлийн чадамжууд нь репрезентацийн объектив харилцааг агуулдаг бол эсрэгээрээ таашаал, үл таашаалыг догдлон мэдрэхүй нь зөвхөн субъектын шийдвэрлэлтийг хүлээн авах чадал²⁷ юм. Иймд бодомжийн чадвар нь өөрийн төлөө ямар нэг зүйлийг шийдвэрлэх бол энэ нь таашаалыг догдлон мэдрэхүйгээс өөр зүйл байж чадахгүй, харин эсрэгээрээ, удаах нь априори зарчимтай бол энэ нь гагцхүү бодомжийн чадвараас л олдох болно. (Kant, 1790/2000, pp. 12-13)

Энэхүү субъектив байдлын онцлог нь бодгаль хүний дотоод төлөвүүдээ ухамсарлаж мэдэх, мөн тэдгээрт хариу үзүүлэх чадавхад агуулагддаг. (Woolwine, 2011) Ийнхүү Кант таашаал, үл таашаалын догдлон мэдрэхүйн априори зарчмыг бодомжийн чадвараас эрэлхийлсэн юм.

Ингэхдээ бодомжийн чадварын эргэцүүлэгч үйл нь өөртөө хууль тогтоох²⁸ байдлаар ажиллахыг Кант онцолсон. Учир нь энэ нь оюун бодол шиг байгальд, эсвэл оюун ухаан шиг эрх чөлөөнд хууль оноодоггүй, мөн үзэгдлүүдэд ойлголт уялдуулахгүй тул оюун бодлын дүрмүүдэд захирагдахгүй. Иймээс гагцхүү өөртөө хууль тогтоох энэхүү бодомжийн чадварын эргэцүүлэгч үйлийг бие даасан шинжтэй болохынх нь хувьд априори зарчим хайх хамгийн тохиромжтой хэлбэр хэмээн тэрээр үзжээ. Уг априори зарчмыг Кант *зорилгод нийцэх чанар*²⁹ хэмээн үзсэн нь бид байгалийн уг зорилгыг мэдэж чадахгүй ч түүнийг зорилго бүхий мэтээр харж, бидний зорилгод нийцсэн мэтээр үнэлснээр байгалийг эмх журамд оруулж ойлгох, улмаар түүнийг механик байдлаар харахгүй байх бололцоо бий болж, байгалийн ертөнцөд ёс суртахууны зорилгуудаа хэрэгжүүлэх бололцоотойг ухаарах нөхцөл бүрдэнэ гэсэн утга агуулж буй. Ийнхүү зорилгод нийцэх чанар хэмээх априори зарчим бүхий бодомжийн чадварын эргэцүүлэгч үйлийн нэгэн онцлог үр дагавар болох гоо зүйн бодомжийг ямар онцлогтойг тайлбарласнаар сүр жавхлангийн тухай бодомжийг авч үзэх боломжтой болох билээ.

Нэн түрүүнд, гоо зүйн бодомж нь ганц тооны бодомж байна. Бид “ер нь сарнай сайхан”, эсвэл “бүх сарнай сайхан” гэх зэргээр ерөнхий ойлголтын хүрээнд, тус ойлголтын дор багтах бүхий л тусгай зүйлсийг хамруулан шүүн дүгнэвэл энэ нь гоо зүйн бодомж бус гоо зүйд суурилсан логикийн бодомж болно. Харин гоо зүйн бодомж нь тусгай нэг үзэгдлийг харгалзан, түүний репрезентацид төрж буй субъектын таашаалд суурилсан байх тул тусгай юмны л тухай байна. Иймд энэ нь “энэ сарнай сайхан юм” гэсэн хэлбэртэй байна.

Түүний дараагаар, гоо зүйн бодомжийн предикат хэзээ ч объектын тухай ойлголт байж чадахгүй. (Kant, 1790/2000, p. 26) Өөрөөр хэлбэл, сайхан, тааламжтай, сэтгэл татам, сүр жавхлантай зэрэг нь объектод байдаг шинж чанар биш, иймд объектын тухай ойлголт ч биш. Иймээс гоо зүйн бодомж нь танин мэдэхүйн бодомжоос ялгаатай. Гэхдээ тухайн объектын тухай ойлголт, мэдлэгтэй байсан ч энэ нь түүнийг гоо зүйн үүднээс шүүн дүгнэхэд нөлөөлөхгүй. Жишээлбэл, би багваахай цэцэг элэг, цөсний үйл ажиллагааг дэмждэг, түүнийг хоол хүнсэнд болон эмийн ургамлын зориулалтаар хэрэглэдэг болохыг мэддэг байлаа ч энэхүү мэдлэг нь өөрийн өмнө буй багваахай цэцгийг хараад сайхан хэмээн үзэх миний шүүн дүгнэлтэд хамааралгүй билээ. Иймд бидний оюун санаа объектод өгөгдмөл байдаг “сайхан”, “сүр

²⁷ *Receptivity* нь доод түвшний танин мэдэхүйн чадамжид хамаарах ба сэрэл мэдрэхүйн өгөгдөл хүлээн авдаг тул ийнхүү орчуулав.

²⁸ *Heautonomy* гэдэг нь гаднын ойлголт, хуульд захирагдахгүйгээр өөрийгөө удирдах, өөртөө хууль тогтоох гэсэн утгатай философийн ойлголт юм.

²⁹ *Zweckmäßigkeit* буюу *purposiveness*-ийг Энхбаатар, А. (2015), Мөнхнасан, Б. (2015) нар *зорилгод нийцэх чанар* хэмээн орчуулсан байдаг.

жавхлантай” гэдэг шинж чанар юм уу ерөөсөө “сайхан объект”, “сүр жавхлантай объект”-ыг идэвхгүйгээр хүлээн авдаггүй болохыг Кант онцолсон юм.

Гоо зүйн бодомж нь объектын тухай ойлголтод суурилдаггүйн дээр үл сонирхохуйд³⁰ тулгуурладаг. Аливаа объектын оршихуйн репрезентацитай холбодог бидний сэтгэл ханамжийг³¹ сонирхол гэнэ. (Kant, 1790/2000, p. 90) Харин гоо зүйн үнэлгээ хийхдээ бид тус объектын оршихуйд ач холбогдол өгөхгүй. Аливаа объект, үзэгдлийн оршихуй, түүний ач тус, бусад оршихуйгаас ялгарах давуу талыг нь харгалзалгүйгээр, түүнд ялгаваргүй хандаж, гагцхүү бидний оюун санаан дахь репрезентаци нь таашаал төрүүлэх эсэхэд л гол анхаарлаа хандуулна. Хэрэв багахан хэмжээний л сонирхол холилдсон бол энэ нь цэвэр гоо зүйн бодомж болж чадахгүй.

Улмаар объектын оршихуйг сонирхох хоёр хэлбэр байна хэмээн Кант үзжээ. Хэрэв аливаа объектыг шүүн дүгнэхэд оюуны сонирхол хутгалдсан бол энэ нь *сайны тухай бодомж*³² болох ба тухайн зүйлийг сайн эсэхийг шүүн дүгнэхийн тулд түүний зориулалтыг харгалзах шаардлага бий болно. Жишээлбэл, бид энэхүү үзэг сайн эсэхийг шүүн дүгнэхийн тулд “үзэг” гэдэг ойлголт руу хандах бөгөөд тухайн үзэг ямар байх ёстой, ойлголтынхоо дагуу зориулалтаа биелүүлж байгаа эсэх, үзэг болохын хувьдаа үүргээ гүйцэтгэж байгаа эсэхэд ач холбогдол өгнө. Харин тус үзгийг зориулалтаа биелүүлж байгаа эсэх нь түүнд гоо зүйн үнэлгээ өгөх үндэслэл болохгүй юм. Иймд гоо зүйн бодомж нь сайны тухай бодомжоос ялгаатай.

Хэрэв аливаа объектыг шүүн дүгнэхэд эмпирик сонирхол хутгалдсан бол энэ нь *тааламжийн тухай бодомж*³³ болно. Бидний сэрэл мэдрэхүйг баясгаж байгаа зүйлийг тааламжтай хэмээн үнэлэх ба дарс уух, амтат зүйл идэх зэргийг энэ хүрээнд багтааж болно. Энэхүү бодомж нь ойлголтод бус бидний догдлон мэдрэхүйд суурилдаг тул гоо зүйн бодомж болох боловч харьцангуй түр зуурын шинжтэй, мөн хувийн сэрэл мэдрэмж, дур сонирхолд тулгуурлах тул тухайн хүний хувьд л хүчин төгөлдөр байна. Харин цэвэр гоо зүйн бодомж нь ойлголтод суурилдаггүй атлаа түгээмэл байх учир тааламжийн тухай бодомж нь ийнхүү гоо зүйн бодомжийн цэвэр хэлбэр болдоггүй.

Ийнхүү сайхан болон сүр жавхлангийн тухай бодомж нь цэвэр гоо зүйн бодомжид багтана. Эдгээр нь үл сонирхохуйд тулгуурласан, түгээмэл, зорилгод нийцэх чанартай, мөн зайлшгүй байна. Эдгээр бодомжийг боловсруулахад бидний танин мэдэхүйн чадварууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс бидний шүүн дүгнэлт, үнэлгээнээс ангид сайхан, эсвэл сүр жавхлан гэдэг зүйл өөрөө бололцоогүй юм. Харин оюун санааны идэвхтэй үйл ажиллагаа буюу танин мэдэхүйн чадамжуудын чөлөөт тоглолтод тулгуурлан бидэнд таашаалын догдлон мэдрэхүй бий болно. Эдгээр чадамж угтаа хүн бүрд байдаг учир цэвэр гоо зүйн бодомж нь ойлголтод тулгуурлалгүйгээр түгээмэл байж чадахыг Кант онцолсон юм. Сайхны тухай бодомжийг боловсруулахад дүрслэн бодохуй ба оюун бодлын дунд чөлөөт тоглолт бий болно. Эдгээр чадвар нь танин мэдэхүйн хүрээнд мөн ажилладаг ч гоо зүйн үнэлгээ өгөх явцад дүрслэн

³⁰ *Disinterestedness* гэдэг нь объектын оршихуйг сонирхож, түүнд ач холбогдол өгөлгүйгээр үнэлгээ өгөх байдлыг илэрхийлдэг тул *үл сонирхохуй* хэмээн орчуулав.

³¹ *Wohlgefallen* буюу *satisfaction* гэх ойлголтоор Кант аливаа гоо зүйн эерэг туршлагыг илэрхийлдэг тул *сэтгэл ханамж*, *Vergnügen* буюу *gratification* гэх ойлголтоор сэрлүүдэд тулгуурласан таашаал, баяр цэнгэл буюу хувийн эрхэмлэл, дур сонирхолд тулгуурласан сэтгэл ханамжийг илэрхийлдэг тул *баясал*, *Lust* буюу *pleasure* гэх ойлголтыг цэвэр гоо зүйн бодомжид холбодог тул *таашаал* хэмээн орчуулав. Энд *сэтгэл ханамж* нь илүү ерөнхий нэр томъёо бол *баясал*, *таашаал* хоёр нь үндсэн сууриараа ялгаатай болно.

³² *Judgment of the good*

³³ Герман хэлний *angenehm* гэх ойлголтыг англи хэлэнд *pleasant, agreeable, enjoyable* зэргээр орчуулдаг ба эдгээр нь аятай таатай, аятайхан, тааламжтай, үзэмжтэй гэх утгыг илэрхийлдэг. Кантын гоо зүйн үзлийн хүрээнд энэхүү ойлголт нь объектын ямар нэг шинж чанар сэрлүүдийг баясгасны дүнд бий болох үнэлгээг илтгэх тул *тааламж* хэмээн орчуулав.

бодохуй нь оюун бодлын ойлголтуудаар хязгаарлагдалгүйгээр өөр хоорондоо эв зохицолтой, чөлөөтэй үйл ажиллагаа явуулна. Харин сүр жавхлангийн тухай бодомжийг боловсруулахад дүрслэн бодохуй болон оюун ухааны дунд энэхүү чөлөөт тоглолт бий болдог байна.

Кант сүр жавхланг математик болон динамик хэмээн ангилсан. Математик сүр жавхлан нь туйлын агуу зүйлийг бүхэллэг байдлаар нь мэдрэх гэж оролдох үед дүрслэн бодохуйн чадвар хязгааргүй рүү тэмүүлэх үеийн туршлага юм. Энд Кант ердийн болон туйлын агуу зүйлийг ялган үзжээ. Бид ердийн агуу зүйлийг түүнтэй ижил төрлийн зүйлстэй харьцуулах замаар ийнхүү үнэлдэг. Жишээ нь, агуу том, сүрлэг барилгыг хараад түүнийг хэмжих шаардлагагүйгээр бусад барилгаас хэмжээгээр илүү болохыг нь таньж, гоо зүйн үнэлгээ өгч чадна. Харин туйлын агуу зүйл нь бүхий л тохиолдолд, ямар ч харьцуулалтгүйгээр агуу хэмээн үнэлэгдэх зүйл юм. Энэ нь харьцуулшгүй агуу учир түүний агуу байдлыг хэмжих хэмжүүр түүнээс гадна байх бололцоогүй ба туйлын агуу зүйл нь өөрийнхөө хэмжүүр болж, бидний анхаарал түүний төрөлхийн агуу байдалд нь татагддаг. Иймд бид туйлын агуу сүр жавхланг байгаль дахь объектуудаас биш, гагцхүү өөрсдийн санаанаас л олж харж чадна. Туйлын агуу сүр жавхлангийн туршлага нь дүрслэн бодохуйн чадварыг тэлэх ба энэхүү тэлэлт нь түүнийг хязгааргүй зүйл рүү зайлшгүй тэмүүлэхэд хүргэдэг. (Allison, 2001) Ингэснээр дүрслэн бодохуй нь бүхэллэг байдлын тухай оюун ухааны санаагаар чиглүүлэгдсэнээр туйлын агуу зүйлийг таньж харах бололцоотой болдог. Ийм учир туйлын агуу хэмээн үнэлэгдэх зүйлийг бид бүрэн дүүрэн, туйлын бүхэллэг байдал хэмээн үзэж болно. Гэхдээ дүрслэн бодохуйн энэхүү үйл ажиллагаа угтаа бүтэлгүйтэж, үл таашаалын догдлон мэдрэхүйг бий болгодог. Ингэснээр бид мэдрэхүйгээс давсан оюун ухааны чадамжтай гэдгээ ойлгож, туйлын агуу зүйл мэдрэгдэгч объект байдлаар оршдоггүйг ухаардаг. Учир нь сэрлүүдийнхээ тусламжтайгаар бүхэллэг байдлаар нь дүрсэлж чадах бүхий л зүйлс бидний мэдрэхүйн талбарт хил хязгаартай бөгөөд оюун ухаан л тэдгээрийг таньж ойлгож чаддаг. Иймд математик хэмжээсээр сүр жавхлантай хэмээн үнэлэгдэх зүйл нь объект биш, харин түүний репрезентацийг харгалзан гоо зүйн бодомж боловсруулах үеийн бидний оюун санааны эв зохицол буюу бидний оюуны төлөв болох юм. (Kant, 1790/2000, pp. 133-134) Түүнчлэн, математик сүр жавхлан нь мэдрэхүйгээс давсан зүйлийг дүрслэх бидний чадвар буюу оюун ухааныг бидэнд илрүүлж өгдөг. (Merritt, 2012) Учир нь энэхүү мэдрэхүйгээс давсан зүйл буюу хязгааргүй нь өөрөө ноумены санаа бөгөөд үүнийг бид мэдэрч чадахгүй, гэхдээ энэ нь үзэгдлийн ертөнцийн үндэс суурь болдог тул түүний тухай бодож чадна. Бид феномен болохын хувьд хязгаарлагдмал оюун санаатай бол ноумен болохын хувьд хязгааргүй зүйлийн тухай бодож чаддаг. Иймээс л эрх чөлөөний ертөнц байгалийн ертөнцөд боломжтой болох юм. Эрх чөлөөний ертөнц үнэхээр бололцоотой эсэхийг бид мэдэж чадахгүй ч түүний тухай ямар ч зөрчилгүйгээр бодож чадна. Гэхдээ байгаль дахь ямар ч объект хязгааргүй байж чадахгүй. Харин хязгааргүй зүйл ийм л байх болов уу гэх нөлөөг бидний оюун санаанд үзүүлдэгт нь хязгааргүй байдлын тухай санаа оршино.

Динамик сүр жавхлан нь байгалийн асар их хүчтэй тулгарах үед түүний дэргэд бие махбодийн хувьд өчүүхэн, сул дорой болохоо мэдрэх ч тэрхүү хүчнээс ангид практик оюун ухааны чадамжтайгаа ойлгох үеийн туршлага юм. Гэхдээ байгалийн асар их хүчнээс үүдэн динамик сүр жавхлангийн туршлагыг олж авахад нэн түрүүнд тухайн хүч бидэнд аюул заналхийлээгүй байх ёстой. Хэрэв бидэнд аюул заналхийлж байсан бол бид гоо зүйн үнэлгээ өгөхөөс урьдаар яаран зугтах байсан нь гарцаагүй. Иймд айдас төрүүлэхүйц бүх зүйл динамик сүр жавхланд тооцогдохгүй. Мөн байгаль айдас төрүүлж байгаа учир л сүр жавхлантай болохгүй. Харин бид аюулгүй зайнаас аянгат цахилгаан, хуй салхи, галт уулын дэлбэрэлт зэргийг ажиглах нь сүр жавхлангийн туршлагыг бий болгоно. Ингэхдээ эд бараа, эрүүл мэнд, амьдрал зэрэг энгийн үед бидний өндрөөр үнэлдэг зүйлс оюун ухаан, ёс суртахуунлаг байдалтай харьцуулахад шалихгүй зүйл болохыг ойлгоход хүргэдэг тэрхүү байгалиас л сүр жавхлант туршлагыг олж авна. (Kant,

1790/2000, р.145) Иймд, бид феномен болохын хувьд хязгаарлагдмал хүчин чадалтай ч ноумен болохын хувьд байгалийн хүчнээс ангид гэдгээ, байгалийн хязгаараас давсан ёс суртахуун руу тэмүүлэх чадалтайгаа ухаардаг. Энэ тохиолдолд дүрслэн бодохуй тухайн хүчийг таньж ойлгох амжилтгүй оролдлого хийж, улмаар оюун ухааны давуу байдлыг ухаардаг. Динамик сүр жавхлангийн туршлагыг олж авах үед бид төгсгөлөг болохоо, амьдрал богинохон болохыг ухаарахын сацуу бидэнд байгалиас давсан өөр хүч буюу практик оюун ухаан байдгийг ойлгодог. (Guyer, 2000)

Ийнхүү хэмжээний хувьд агуу зүйл математик сүр жавхланд, хүчний хувьд агуу зүйл динамик сүр жавхланд холбогдоно. Гэвч тэдгээр зүйл өөрөө сүр жавхлантай бус, харин бидэнд оюун ухааны чадвараа ухаарах бололцоог олгодог ба ийнхүү ухаарах нь өөрөө сүр жавхлант туршлага болж өгдөг. Энэ үед бид өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаа буюу байгалийн ертөнцийн хүрээнээс дээш өнгийж, улмаар бидний оюун санаа, сэтгэл өргөгдөж өгдөг. Иймд сүр жавхлангийн тухай бодомж нь дүрслэн бодохуй ба оюун ухааны хоорондын чөлөөт тоглолтод тулгуурлана. Харин дүрслэн бодохуй ба оюун бодлын чөлөөт тоглолт явуулах гэсэн зорилгод сүр жавхлан эсрэгцэж, улмаар бидэнд үл таашаалын догдлон мэдрэхүй төрнө. Гэвч оюун санааг бүхэл болохынх нь хувьд түүний зорилгод нийцэх тул таашаалын догдлон мэдрэхүй бий болно. Үүнээс үүдэн сүр жавхлангийн тухай бодомжийг *зорилгод эсрэгцсэн зорилгот чанартай* байна хэмээн Кант үзжээ. Энэхүү зорилгот чанар нь байгалийн биш, эрх чөлөөний ойлголтод хамаарах тул объектын репрезентацийн хэлбэрийг харгалзах шаардлагагүй болно. Сайхны тухай бодомжийг боловсруулахад бид тухайн репрезентацийн хэлбэрийг харгалздаг бол сүр жавхлангийн тухай бодомж нь хэлбэрээс үл хамаарсан, цаг хугацаа, орон зайн хэмжүүрээр таньж харах бололцоогүй зүйлийн үнэлгээ байдаг. (Crawford, 2013) Өөрөөр хэлбэл, сүр жавхлантай хэмээн үнэлэгдэх зүйл нь мэдрэхүйд өгөгдсөн хэлбэрт бус, харин бидний оюун ухааны санаануудад оршдог. Иймээс жинхэнэ сүр жавхланг бид оюун санаанаас л олж чадна. Харин объектыг харгалзан ярих үедээ бид сүр жавхлантай гэх бус, сүр жавхлант байдлыг дүрслэн үзүүлж, эсвэл өдөөхөд тохиромжтой хэмээж чадна. Үүнээс үүдэн сүр жавхлан бол бидний аливаа объект, үзэгдэлд өгдөг үнэлгээ бус харин оюун санаа өөрийн санаандаа өгч буй үнэлгээ хэмээн ойлгож болно. Математик сүр жавхлангийн туршлага нь агуу зүйлийг мэдрэх гэж оролдох үед бүхэллэг байдлыг шаардах оюун ухааны дуу хоолойг бид өөрөөсөө сонсох үед бий болох бол динамик сүр жавхлангийн туршлага нь байгалийн хүчнээс давсан бидний хүч, чадвар буюу оюун ухааныг бидэнд илрүүлэх үед бий болно.

Математик сүр жавхлан нь хэмжээний хувьд агуу бол динамик сүр жавхлан нь хүчний хувьд агуу болохыг бид харж болно. Эхний тохиолдолд, хэмжээний хувьд агуу зүйлийг нэг интуициар бүхэллэг байдлаар барьж авахыг оролдох үедээ дүрслэн бодохуй нь хязгаартаа тулж, оюун ухаан руу ханддаг. Ингэхдээ бид хязгааргүй, хэмжээлшгүй зүйлийг байгалийн ертөнцөд хүртэн мэдэрч чадахгүй ч чухамхүү тэрхүү ертөнцөд түүний тухай бодож чадахаа ойлгодог билээ. Удаах тохиолдолд аюул заналхийлсэн агуу хүчийг аюулгүй зайнаас ажиглах үед дүрслэн бодохуй тэрхүү хүчний агуу байдлыг таньж ойлгох гэж оролдох үедээ бүтэлгүйтсэнээр мөн оюун ухаан руу хандана. Ингэхдээ бид байгалийн хүчнээс давсан практик оюун ухаан гэх өөрийн хүчийг ухаардаг билээ. Улмаар сүр жавхлан нь ёс суртахууны санаануудыг байгалийн ертөнцөд хүндэлж, өндрөөр үнэлэх бололцоог бидэнд олгосноор бидний байгалийн ертөнцийн тухай бодлыг ёс суртахууны ертөнцийн тухай бодол руу чиглүүлж өгдөг байна.

Сүр жавхлангийн туршлагыг уг чанараараа зорилгот байдалтайн хувьд нь амьтдаас, хүний зорилгоор хэлбэр, хэмжээ нь тодорхойлогдож байдгийн хувьд нь урлагаас, мөн байгаль дахь төгсгөл нь тодорхой зүйлсээс бус зөвхөн организм үүсэхээс өмнө хэлбэржсэн онгон байгалиас³⁴

³⁴ Raw nature

л олж авах боломжтой хэмээн Кант үзсэн нь олон судлаачдыг урлагийн сүр жавхлангийн бололцоог эрэлхийлэхэд хүргэсэн байдаг. Гэвч тэрээр математик сүр жавхлангийн жишээ авахдаа Египетийн пирамид, Гэгээн Петрийн сүм зэргээр урлагийн бүтээлийг онцолсон. Энэ нь түүний тодорхойлсны дагуу организм үүсэхээс өмнө хэлбэржсэн онгон байгаль биш болохыг бид харж байна. Харин Кант урлагийн бүтээл дэх сайхны тухай асуудлыг авч үзэхдээ урлаг нь байгаль мэт үнэлэгдэх үедээ сайхан байх бололцоотойг онцолсныг энд дурдъя. Үүний адилаар урлагийн бүтээл нь “онгон байгаль мэт” үнэлэгдэх үедээ сүр жавхлангийн догдлон мэдрэхүйг бий болгох боломжтой гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, тухайн бүтээлийг ямар зорилготой бүтээснийг харгалзалгүйгээр, гагцхүү бидний оюун санааг өргөлтөд оруулж байгаа эсэхийг, мөн тэрхүү үзэгдлээр дамжуулан бидэнд ямар санаа төрж буйг харгалзан тийнхүү шүүн дүгнэх боломжтой. Романтицизмын үед хүчит далайн шуурга, сүрлэг уулс, аянга цахилгаан зэргээр дамжуулан сүр жавхланг уран зурагт дүрслэх оролдлогууд ихээр гарсан. Гэвч сүр жавхланг дүрслэхийг оролдсон урлагийн бүтээлүүд нь заавал сүр жавхлант туршлагыг бий болгох албагүй. Харин зарим урлагийн бүтээл сүр жавхланг бидэнд мэдрүүлж, оюун санаанд хөдөлгөөн бий болгох боломжтой. (Blevins, n.d.) Иймд Кант сүр жавхланг урлагт дүрслэх бололцоог үгүйсгэсэн ч урлагаар дамжуулан сүр жавхлант туршлага олж авах бололцоог үгүйсгээгүй хэмээн үзэж болохуйц байна.

Сайхан болон сүр жавхлангийн тухай Бюркийн үзлийг психологийн, аль эсвэл физиологийн үүднээс өгсөн тайлбар хэмээн Кант үзсэн юм. Учир нь Бюрк сайхан болон сүр жавхлангийн туршлагыг хүний сэтгэл санаа болоод бие махбодод үзүүлэх нөлөөнд тулгуурлан зааглан үзсэн. Харин Кант сүр жавхланг бидний боловсруулах бодомжоос, улмаар, бидний оюун санаанаас ангид байдлаар байх бололцоогүйг харуулсан юм. Түүнчлэн, сайхан болон сүр жавхланг объектод байдаг шинж чанар мэтээр үзээгүй нь гоо зүйн туршлагын хүрэн дэх бидний оюун санааны идэвхтэй үйл ажиллагааны ач холбогдлыг харуулсан.

Бюркийн нэг нь нөгөөдөө хувирч боломгүй мэдрэмжүүдийг хольж догдлон мэдрэх боломжтой гэх санаа Кантын сүр жавхлангийн тухай ойлголтод нөлөөлсөн юм. Ингэхдээ тэрээр сүр жавхлангийн туршлага нь дүрслэн бодохуй, оюун бодлын харилцааны хүрээнд үл таашаалыг бий болгодог бол оюун санааг бүхэл болохынх нь хувьд таашаалын догдлон мэдрэхүйг төрүүлдэг хэмээн үзсэн. Түүнчлэн, Кантын динамик сүр жавхлангийн тухай ойлголтод Бюркийн сүр жавхлангийн тухай ойлголт нөлөөлсөн байна. Хэрэв тэд илүү хожуу амьдарч байсан бол дэлхийн нэг, хоёрдугаар дайн, цөмийн дэлбэрэлт зэрэг нь хүн төрөлхтөнд асар их сүйтгэх хүчийг мэдрүүлсний дээр ахархан амьдралтай болохыг сануулж, өдөр тутмын амьдралд аюул занал учруулж, айдас хүйдсийн мэдрэмж төрүүлснээрээ түүнийг аюулгүй зайнаас ажсан нэгэн сүр жавхлангийн туршлагыг олж авсан хэмээн хэлэх байсан биз. Үүнтэй холбоотойгоор хүйтэн дайны үеийн цөмийн зэвсгүүд сүрдэлт, айдас хүйдэс болон технологийн гайхширлын догдлон мэдрэхүйг бий болгож, улмаар *атомын сүр жавхлан* гэх ойлголтыг гэрэл зурагчид, философичид болон зохиолчид ашиглах болжээ. (Hales, 1991)

Математик сүр жавхлангийн тухай Кантын ойлголт нь сүрлэг уулс, одот тэнгэр, пирамид зэрэг бидэнд аюул заналхийлж, айдас төрүүлдэггүй атлаа хэмжээний хувьд агуу хэмээн үнэлэгдэх үзэгдлүүдийг сүр жавхлант туршлагад хамаатуулан үзсэнээрээ онцлог билээ. Фридрих Шиллер түүний үзлийг дэмжин, сүр хүчит объектод тулгарах үед сүр жавхлант шинжийг нь бус агуу байдлыг л нь хүлээн авах бөгөөд байгалийн юм уу цэргийн хүчний эсрэг хүчээ алдах үед л жинхэнэ утгаар сүр жавхланг мэдрэнэ хэмээн үзжээ. Гегель мөн сүр жавхлангийн тухай Кантын санааг хөгжүүлэхийг оролдсон бол Шопенгауэр сүр жавхлангийн тухай Бюркийн санааг хөгжүүлэхийг зорьсон. (Holmqvist & Pluciennik 2002) Гэвч Бюрк, Кант болон Германы романтикуудын гоо зүйн үзлийн төвд байсан сүр жавхлан нь хэтэрхий хийсвэр, метафизикч шинжтэй, нүсэр, эксклюзив шинжтэй зэргээр үнэлэгдэх болж, мөн нөгөө талаас гоо

зүйн онолын төвд өөр олон асуудал гарч ирэх болсноор сүр жавхлан нь гоо зүйн онолын ихээхэн хэлэлцүүлдэг асуудал байхаа нэгэнт больжээ. Гэхдээ хэмжээний хувьд асар их зүйлийг цогц, бүхэллэг байдлаар нь таньж ойлгох, ажиглагчид аюул заналхийлээгүй ч өдөр тутмын үйл ажиллагаанд тасалдал үүсгэх гэсэн энэхүү туршлагыг орчин үеийн гоо зүй дэх *технологийн сүр жавхлан* болон *авангард сүр жавхлан* гэх ойлголтуудад нөлөөллөө хэрхэн үзүүлснийг авч үзье.

Лео Маркс (1964) технологийн сүр жавхлан нь хязгаарлагдмал бус боломжит байдлаас төрөх цочролын мэдрэмжээс үүддэг хэмээн үзсэн. Дэвид Най (1994) америкчууд анхлан байгалийн сүр жавхланг хүлээн авч буй мэтээр технологийн сүр жавхланг хүлээн авсан бөгөөд байгалийн сүр жавхланг бишрэх бишрэл нь үйлдвэр, нисэх хүчин, автомашин, дайны зэвсэг болон компьютерын сүр жавхлангаар солигдсон хэмээн үзжээ. Тооцооллын эрин үе дэх математик сүр жавхлан нь комбинаторийн огцом өсөлт байдлаар илэрч буй. Технологи шинэ байхаа больж, өдөр тутмын амьдралд хаа сайгүй байдаг болох цагт технологийн сүр жавхлангийн тухай дискурсуудтай холбоотой хүн төрөлхтний хөгжил дэвшилд найдах найдлага ч мөн замхран одох болно. (LeBel, 2012) Технологийн сүр жавхлангийн тухай ойлголтоос улбаалан интернэтийн орчинд миф бүтээж буй явдлыг Винсент Моско (2004) *дижитал сүр жавхлан* хэмээн нэрлэсэн байна.

Технологи шинэ байхаа больж, өдөр тутмын амьдралд хэвшмэл болсон цагт технологийн сүр жавхланг ч бид мэдрэхээ болино. Дээр дурдсаны адилаар бид тэрхүү технологи угаас л амьдралын нэг хэсэг байсан мэтээр санаж, дараагийн шинэ зүйлийг хүлээн сууна. Гэтэл одоо үед интернэт хайлт дахь хязгааргүй их үр дүн, судалгааны үй олон материал болон хиймэл оюун ухаантай холбоотойгоор сүр жавхлангийн тухай ойлголтыг авч үзэж болох юм.

1985 онд Лиотар *Сүр жавхлан ба авангард* гэх эрдэм шинжилгээний бүтээл бичсэнээр авангард сүр жавхлан гэх ойлголтыг судлаачид хэрэглэх болов. Тэрээр сүр жавхлан бол урлагийн институтэд заналхийлсэн амьдралын хэлбэр хэмээн үзсэн. Урлаг нь институтэд ирээдүйгээ төлөвлөх, тооцоолох, хэлбэржүүлэх бололцоо олгодог бөгөөд энэ үйлийг сургууль, программ зэргээр дамжуулан гүйцэтгэдэг байна. Эдгээр нь эргээд тус институтийн ирээдүйн хөгжлийг тодорхойлогч буюу урлагийн үйлдвэрлэлийг зохицуулагч систем болж өгдөг. Ийнхүү ирээдүйгээ төлөвлөж, удирдах гэсэн тасралтгүй үйл ажиллагаанд авангард урлагийн сүр жавхлан саад учруулдаг. Авангард нь хуучин программыг тасалдуулах байдлаар урлагийн бүтээлийг ажиглагчид цочрол өгч, тэгснээр аюултай мэдрэмж төрүүлж, самууруулж орхидог. Энэ утгаар ажиглагчийн амьдрал заналхийлэлд өртөөгүй ч түүний соёлоор нь нөхцөлдсөн горьдлого нь гэнэтийн байдлаар талаар болдог. Авангард урлаг нь өөрөө сүр жавхлант бус, харин урлаг хэмээх үйл ажиллагаа буюу давталтын төгсгөлөг байдлыг ухамсарлах үед ажиглагчид төрөх эсэргүүцэл, анти-авангард загвараар мэдэрч, бодох тэрхүү хүрээнд л сүр жавхлан яригдана хэмээн Лиотар үзсэн. (Groys, 2012) Хэрэв аливаа эсэргүүцэлгүйгээр түүнийг хүлээн авч, хүлээн зөвшөөрч байвал тэр хүн тасалдлын цочролыг мэдэрч чадахгүй. Өөрөөр хэлбэл, дасал болсон, давтагдсаар ирсэн урлагт авангард урлаг тасалдал үүсгэж, тогтсон байдал, хандлагыг эвдэж буй. Гэтэл одоо авангард урлаг өөрөө уламжлал болсон нь жинхэнэ авангардыг гажуудуулсан. Учир нь капиталист урлагийн зах зээл бий болж, тэр нь ашгийн төлөө хуучныг халж, шинийг тасралтгүй бий болгосноор хүмүүсийг цаг ямагт шинэ зүйлд л татагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Шинээр бий болсон, хуучныг эвдэх гэсэн урлагийн оролдлогууд хаа сайгүй бий болсон нь жинхэнэ авангард бус, харин *эвдэхүй төдий хэлбэртэй*, жинхэнэ утгаар сүр жавхлант мэдрэмж төрүүлэхгүй үй олон урлагийн бүтээлийг бий болгосон. Эдгээр нь утгаа хуучны давталтыг ердөө л шинэ элементтэй хослуулсан шинэ урлаг төдий юм. Постмодерн хэмээн нэрлэгдэх эдгээр урлаг хангалттай авангардч биш гэж тэрээр үзээд эдгээр нь лут цочрол өгөхийн оронд хөнгөхөн гижигдээд л өнгөрдөг болсныг онцолсон. (Groys, 2012)

Авангард сүр жавхлан нь урлагийн хуучин программыг тасалдуулах байдлаар ажиглагчийг цочроож, улмаар хуучин хэв маягт аюул занал учруулж, хүчтэйгээр эвддэгийн хувьд түүнд сүр жавхлангийн тухай Кантын үзэл шингэмэл байгааг харж болно. Гэсэн ч авангард урлаг өөрөө уламжлал болсон тул урлагийн цаашдын нөхцөл байдал ямар байх талаар асуудал гарч байна. Урлагийн түүхэнд тогтсон хандлагыг хүчтэйгээр эвдэж, олон хүний гайхширлыг төрүүлсэн бүтээлүүд бий. Марсел Душаны *Оргилуур* ч мөн энэ утгаар өнөөг хүртэл олон хүний хэлэлцүүлгийн хүрээнээс гараагүй хэвээр. Гэсэн хэдий ч нэг талд поп урлаг эрчимтэй хөгжиж, уран бүтээлчид үзэл санаа, урлагийн төлөө бус, ашиг хонжооны төлөө бүтээл туурвих болж, тэдгээр нь олны нүд, чихийг хужирлах “ганган” элемент агуулдаг учир олонд таашаагдаж, Лиотарын утгаар *давталт* хийсээр байдаг. Нөгөө талд хэв загвар үгүй, бүтээлч, гажууд мэт харагдаж, сонсогдохуйц, тогтсон хэм хэмжээг зөрчсөн мэт “хуурмаг” авангард урлагийн бүтээлүүд хаа сайгүй байх болсноор урлагийн төгсгөл ирсэн эсэх, үүнээс цааш шинэ парадигматик бүтээл гарах эсэх эргэлзээтэй хэвээр.

Үүнээс үүдэн орчин үеийн гоо зүйн онол дахь сүр жавхлангийн тухай ойлголт нь нэг талд интернэтийн орчин дахь хэмжээлшгүй их илэрцийг хүлээн авах гэсэн бүтэлгүй оролдлого, нөгөө талд хэвшмэл болж буй урлагийн бүтээл, технологийн хүрээн дэх тасалдалтай холбогдох болсон байна. Эдгээр нь аливаа нэг объектод байдаг сүр жавхлант шинж чанарыг бус, харин хурдацтайгаар хөгжиж буй өнөөгийн технологи болон урлагийн ертөнцөөс хүний олж авах нарийн ээдрээтэй, сүрдмээр туршлага, тасалдлыг илтгэх болсноороо Кантын үзсэний адилаар сүр жавхлангийн хүний оюун санаанд үзүүлэх нөлөөнд тулгуурлаж байна.

Дүгнэлт

Анх утга зохиол, уран илтгэхүйн ухааны ойлголт байсан сүр жавхлан нь тааламжит аймшиг, айдас хүйдэст баяр баясал гэх холимог мэдрэмжтэй холбогдон гоо зүйн онолын хүрээнд XVIII зууны үеэс орж иржээ. Улмаар Эдмунд Бюрк сайхан болон сүр жавхланг хүнд үзүүлэх физиологи, психологийн нөлөөнд нь тулгуурлан ялгасан. Харин Кант сайхан болон сүр жавхланг бидний бодомжийн чадвараас ангид байх бололцоогүйг онцолсон юм.

Ингэхдээ тэрээр оюун санааны идэвхтэй үйл ажиллагаа явуулж чаддаг ахуй болохын хувьдаа бид объектын шинж чанарыг идэвхгүйгээр хүртэж, түүнээс таашаал авсны дүнд тус объектыг үнэлдэггүйг онцолсон. Иймд бидний бодомжоос ангид сайхан, эсвэл сүр жавхлан гэх зүйл бололцоогүйг харуулснаараа Кантын гоо зүйн онол ихээхэн ач холбогдолтой юм. Сүр жавхлангийн туршлага бий болох үед дүрслэн бодохуй, оюун бодлын хооронд чөлөөт эв зохицол үүсч чадахгүй бөгөөд хязгаартаа тулж, түүнээс цааш тэлэхийг эрмэлзсэн дүрслэн бодохуй нь оюун ухаан руу ханддагаараа ёс суртахуунтай илүү нарийн холбоотой байдаг. Ингэснээр байгалийн ертөнцөд хязгааргүй, хэмжээлшгүй зүйлийн тухай бодох бололцоотойгоо ухаарах, байгалийн хүчнээс давсан практик оюун ухааны чадвартайгаа ойлгох бололцоо олгодог юм. Энэхүү үнэлгээг бид хэлбэрээс үл хамааран, гагцхүү өөрийн санаандаа оноодог тул энэ нь феноменал ертөнцөөс давж, ноуменал ертөнц рүү ханддаг. Энэ утгаар сүр жавхлангийн туршлага нь Кантын шүүмжлэлт философид цэвэр оюун ухааныг практик оюун ухаантай холбох үүрэг гүйцэтгэдэг.

Харин түүний боловсруулсан сүр жавхлангийн тухай ойлголт нь Бюркийн сүр жавхлангийн тухай онолын хамтаар тус ойлголтын гоо зүйн хүрээн дэх суурийг тавьж өгсөн юм. Улмаар XVIII, XIX зууны гоо зүйн онолын хүрээнд сайхантай эн зэрэгцэх гол ойлголт байсан сүр жавхланг хэтэрхий хийсвэр, метафизикч шинжтэй, нүсэр, эксклюзив шинжтэй зэргээр үнэлэх болсноор гоо зүйн хэлэлцүүлгийн гол асуудал байхаа больсон хэдий ч цөмийн дэлбэрэлт, технологи болон авангард урлагийн хүрээнд яригдсаар байна.

Постмодерн үед сүр жавхлангийн тухай үзэлд ажиглагч, хэрэглэгчдэд цочрол өгөх, өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд тасалдал үүсгэх, эсвэл хувиргах, хязгаарлагдмал бус боломжит байдлын тухай санаанууд нь сүр жавхлангийн тухай Кантын үзлээс утгын эхээ авсан байна. Харин бид XVIII-XIX зууны үед сүр жавхлант туршлагын гол объектод тооцогдож байсан байгалиас гадна зорилго бүхий хүний үйл ажиллагааны үр дүн болсон авангардч урлагийн бүтээл, техник технологиос сүр жавхлангийн туршлагыг олж авах болжээ.

Ном зүй

1. Гомбосүрэн, Ц. (2024). *Философи* (6 дахь хэвлэл). МУИС Хэвлэлийн газар. Улаанбаатар хот.
2. Гулыга, А. В. (2015). *Үнэн, сайн үйл, сайхан зүйл* (Б. Мөнхнасан, Орч.). А. Энхбаатар, Д. Мөнхцэцэг (Ред.), Кант-ын V бүлэг (хх. 203-241). Монсудар хэвлэлийн газар. (1981). Улаанбаатар хот.
3. Дэлгэрмаа, Б. (2022). Гайхамшигт зүйл. Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн, *Философийн шинэ нэвтэрхий толь* (хх. 302-307). Соёмбо принтинг. Улаанбаатар хот. Төмөрбаатар, Ж. (1998). *Гоо зүйн үндсэн категориуд*. (хх. 27-41).
4. Кант, И. (2024). *Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй*. (Ч. Даваадаш, Орч.). “Адмон принт” ХХК. (1781). Улаанбаатар хот.
5. Төмөрбатаар, Ж., Дэлгэрмаа, Б. (2007). *Германы сонгодог гоо зүй*. Улаанбаатар хот.
6. Энхбаатар, А. (2015). *И.Кантын боловсруулсан гоо зүйн категорийн асуудалд*. Гоо зүйн боловсрол ба орчин үе-Д.
7. Allison, H. E. (2001). The Sublime. H. E. Allison-Д, *Kant's Theory of Taste* (pp. 302-344).
8. Blevins, S. A. (n.d.). Nature, Fine Art, and The Other One: A Defense of the Artistic Sublime in Kant.
9. Burke, E. (1757). *A Philosophical Enquiry into the Origin of Our Ideas of the Sublime and Beautiful*. London.
10. Crawford, D. W. (2013). Kant. In D. M. Berys Gaut, *The Routledge Companion to Aesthetics, Third Edition* (pp. 46-55). Oxford: Routledge.
11. Doran, R. (2015). *The Theory of the Sublime from Longinus to Kant*. Cambridge University Press.
12. Dunn, N. (2024). Kant on Moral Feeling and Practical Judgment. *Rethinking Kant*, 72-96.
13. Groys, B. (2012). Jean-François Lyotard: The Roller Coaster of the Sublime. In B. Groys, *Under Suspicion: A Phenomenology of Media* (pp. 148-160). Columbia University Press.
14. Guyer, P. (2000). Editor's introduction. I. Kant-Д, *Critique of the Power of Judgment*.
15. Guyer, P. (2020). *18th Century German Aesthetics*. Retrieved from Stanford Encyclopedia of Philosophy: <https://plato.stanford.edu/entries/aesthetics-18th-german/>
16. Hales, P. B. (1991). The Atomic Sublime. *American Studies*, 5-31.
17. Holmqvist, J. P. & & Fluciennik (2002). A Short Guide to the Theory of the Sublime. *Style*, 718-736.
18. Kant, I. (1790/2000). *Critique of the Power of Judgment*.
19. LeBel, S. (2012). Wasting the Future: The Technological Sublime, Communications Technologies, and E-waste.
20. Merritt, M. M. (2012). The Moral Source of the Kantian Sublime. In P. Guyer, *The Sublime from Antiquity to the Present*.
21. Woolwine, S. (2011). Systematicity in the Critique of Judgment: The Emergence of a Unified Subject. *Journal of Speculative Philosophy*, 343-358.
22. Zangwill, N. (2023 edition). *Aesthetic Judgment*. Retrieved from The Stanford Encyclopedia of Philosophy: <https://plato.stanford.edu/archives/sum2023/entries/aesthetic-judgment/>

Interpreting Kant's Concept of the Sublime in Connection with Modern Aesthetic Theory

Immanuel Kant is regarded as a prominent philosopher in defining the concept of the aesthetic sublime. The significance of the concept of the sublime in his Critique of the Power of Judgment lies in bridging the gulf between the spheres of nature and freedom. Through two distinct modes, the mathematical and dynamical sublime, Kant reveals how aesthetic experience transcends mere sensory perception. The mathematical sublime allows the imagination to seek the totality of the absolutely great, while the dynamical sublime reminds us of our capacity for practical reason that stands superior to nature. For Kant, sublimity does not reside in the object itself, but in our minds. As a pure aesthetic judgment, the judgment of the sublime is subjective universal, necessary, and grounded in disinterestedness and purposiveness. Although the concept of the sublime significantly influenced German Romanticists, it gradually ceased to be the primary concern of aesthetics. We argue that contemporary aesthetic concepts such as the atomic sublime, the avant-garde sublime, and the technological sublime draw their conceptual lineage from the Kantian understanding of the sublime.